



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2021.01.18 № 01

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-ийг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна.

Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын улмаас Монгол Улсын Засгийн газар удаан хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, хөл хорио тогтоосноор иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж, улсын эдийн засаг хүнд байдалд ороод байна. Монголчууд бид хэдийгээр нийтээрээ хамтран тэмцсэний үр дүнд удаан хугацаанд тус цар тахал дэлгэрэхээс хамгаалж чадсан боловч өнөөдөр харамсалтай нь хариуцлагагүй үйлдэл, үйл ажиллагааны улмаас энэхүү өвчний халдварыг дотооддоо алдаад байна.

Монгол Улсад, монголчуудад энэхүү хүнд хэцүү хохирлыг учруулаад байгаа гол шалтгаан нь цар тахлын халдвар болон дэгдэлт бус харин Таны тэргүүлж буй Засгийн газар, Улсын онцгой комисс, түүнчлэн Нийслэлийн онцгой комиссын хариуцлагагүй байдал, эргэж буцсан, тодорхойгүй, хүний эрхийн мэдрэмжгүй шийдвэр, үйл ажиллагаанаас болсон гэж дүгнэж байна.

Гадаад харилцааны яамны Консулын газрын мэдээлэлд дурдагдсанаар нутаг буцах хүсэлтээ илэрхийлсэн 6800 орчим иргэд байгаагаас 4700 орчим нь БНСУ-д байгаа иргэд байна. Тэдгээрээс нэн яаралтай ирэх шаардлагатай нь 1500 орчим иргэн байгаа юм байна. Сүүлийн өдрүүдэд цөхөрч аргагүйдсэн иргэд Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газрын үүдэнд эсэргүүцлээ илэрхийлж, суулт хийхдээ тулж, эх орондоо ирж амжилгүй хүний газар нас барсан тохиолдлууд гарсаар байхад тусгай үүргийн онгоцоор улс төрчид, тэдгээрийн хамаарал бүхий этгээдүүд зорчсон гэсэн мэдээлэл түгэж, иргэдийн бухимдлыг төрүүлээд байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 18-д заасны дагуу Монгол Улсын иргэн нь “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.” гэж заасан бөгөөд уг эрхээ баталгаатай эдлэхээр зохицуулагдсан. Мөн Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-т “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан. Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн

2020090101


хугацаанд гадаад улсуудад дээр дурдсанчлан гацсан байгаа Монгол Улсын иргэдийн Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө хууль зүйн үндэслэлгүйгээр зөрчигдсөн, Үндсэн хуулийн зөрчлийн шинжтэй нөхцөл байдал үүсээд байна гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын гишүүний хувиар Танаас хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд дараах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэхийг шаардаж байна. Үүнд:

1. Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын улмаас гадаадад гацсан, эх орондоо яаралтай эргэн ирэх шаардлагатай иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн, хямралт байдлыг яаралтай шийдэж, иргэдийг татаж авах ажлыг зохион байгуулах;
2. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн үйл ажиллагаа, санхүүжилтийг яаралтай сайжруулж, ил тод болгох, гадаад улсад бодитоор санхүүгийн хүндрэлд өртсөн иргэдийг амьжиргааны суурь хэрэгцээгээ хангахуйцаар дэмжих, туслах ажлыг зохион байгуулах;
3. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль тогтоомж болон холбогдох бусад захиргааны актууд хүний эрхийг хангаж буй эсэх, хууль тогтоомжид нийцэж буй эсэх талаар хууль зүйн дүн шинжилгээ хийж, гадаадад гацсан иргэдийн асуудлыг оновчтой, тодорхой байдлаар шийдэх, хүний эрхийн зохисгүй хязгаарлалтуудыг арилгах, боловсронгуй болгох;
4. Гадаадад гацсан иргэдийг эх орондоо авчрахад шаардлагатай нэмэлт хөрөнгө гаргах, хуваарилах;
5. Гадаадад гацсан иргэдээ татан авах болон гадаад улсад оршин сууж буй иргэдээ хэрхэн дэмжих, хамтран ажиллах талаар тодорхой бодлого, төлөвлөгөө байгаа бол түүнийгээ нээлттэй танилцуулах, уг асуудлаар хилийн чанад дахь 200,000 гаруй иргэд, тэдгээрийн санаачлагаар байгуулагдсан иргэний нийгмийн байгууллагуудтай Ерөнхий сайдын түвшинд хамтран ажиллах ажлыг зохион байгуулж, тэдний хүч оролцоог нэгтгэх, улмаар удахгүй болох Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох эрхийг нь бодитойгоор хангах арга хэмжээг одооноос авч хэрэгжүүлэх зэрэг шаардлага хамаарна.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасан хугацаанд ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Т.ДОРЖХАНД

2020000101